

## НОМ ӨГҮҮЛЛИЙН ШҮҮМЖ

**ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ  
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТОЙМ (Хөх хот, 1979)  
ХЭМЭЭХ НОМЫН ТУХАЙ**

(шүүмж)

Энэхүү зохиолын эхийг анх БНХАУ байгуулагдсан 10 жилийн ойн өмнө 1959 онд бэлтгэжээ. 1960-1965 онд гурван удаа үлэмжхэн засвар хийсний эцэст ӨМӨЗО байгуулагдсаны 20 жилийн ойгоор 1967 онд хэвлэхээр шийдвэрлэжээ. Гэвч уг зохиол соёлын хувьсгалын үед шүүмжлэлд өртсөний улмаас зөвхөн 1979 онд одоогийн байр сууринаас дахин нэмэлт засвар хийсний эцэст хэвлэгдсэн байна.

Нийт 5 бүлэг, 18 зүйлтэй энэхүү номонд ӨМӨЗО байгуулагдсан 1947 оноос хойш соёлын хувьсгалын өмнөх 1965 он хүртэл тус ӨЗО-ны эдийн засгийн хөгжлийн 19 жилийн түүхийг нэлээд дэлгэрэнгүй авч үзэн, түүний ололт амжилт, алдаа дутагдлыг дүгнэн цэгнэн цаашдын хөгжилд хэрэг болох зарим зүйлийг тодруулах оролдлого хийжээ. Уг номыг зохиогчид чухамхүү 1948-1965 оны хоорондох үеийг сонгож авсан нь санамсаргүй зүйл биш юм. ӨМӨЗО оршин тогтносон эхний 10 жилийн хугацаанд Өвөр Монголын ард түмэн эдийн засгийн бүтээн байгуулалтын янз бүрийн салбарт зарим тодорхой амжилт олжээ. Энэхүү номын эхний бүлэгт Өвөр Монголын ӨЗО байгуулагдахын өмнөх үеийн нийгэм эдийн засгийн байдлыг авч үзжээ. Дараагийн бүлэгт ӨМӨЗО байгуулагдсаны дараа ав хэрэгжүүлсэн ардчилсан өөрчлөлт, ялангуяа Өвөр Монголын зүүн хэсэгт 1947-1948 онд баруун хэсэгт 1951-1952 онд явуулсан газрын шинэтгэлийг бичжээ. Үүнд Өвөр Монголын мал аж ахуй эрхэлдэг нутагт тариалангийн нутгаас ялгавартай хандаж зарим онцлог аргаар ардчилсан өөрчлөлт хийснийг зохиогчид тусгасан боловч бүр тэр үед мал аж ахуйг хохироож, тариаланг өргөтгөх хандлага илэрч байсныг зохиогчид дурьдалгүй өнгөрчээ.

Гуравдугаар бүлэгт ӨМӨЗО-нд явагдсан социалист өөрчлөн байгуулалтын явцыг авч үзжээ. Хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулахад 15 жилийн хугацаа шаардагдана гэж үзэж байсан хирнээ 1953-1956 онд тариалан эрхэлдэг районд, 1952-1958 онд мал аж ахуй эрхэлдэг районд үйлдвэрлэлийн хоршооллыг үндсэнд нь байгуулж дуусгажээ. Хэдийгээр тарианийн районтэй харьцуулбал мал аж ахуйн районд хоршооллох хөдөлгөөнийн 1952 оноос эхлэн 1956 он хүртэл алгуур явуулж байсан боловч 1957-1958 онд гэнэт түргэвчлэн хоршооллосон нь дараахь баримтаар харагдаж байна. Үүнд 1957 онд Өвөр Монголын малчин өрхийн дөнгөж 27,09% нь үйлдвэрлэлийн хоршоололд хамрагдаж байсан бол 1958 онд даруй 80,16%-ийг хамруулсан байна. (200-р тал)

ӨМӨЗО-нд ардын коммун байгуулах хөдөлгөөн мөн л ийм түргэн хурдацтай явагджээ. Тариалан эрхэлдэг районд 1958 оны 9,10-р сард, мал аж ахуй эрхэлдэг районд мөн 9-12-р сард коммунчлах хөдөлгөөнийг явуулж дуусгажээ.

Өгүүлэн буй гомын дөрөвдүгээр бүлэгт БНХАУ-ын улс ардын аж ахуйг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө (1953-57), хоёрдугаар таван жилийн төлөвлөгөө (1958-1962), зохицуулалтын үеийн (1963-1965) ӨМӨЗО-ны эддийн засгийн хөгжлийн явцыг авч үзжээ. Уг номыг зохиогчид Өвөр Монголын эдийн засагт 1958-1960 онд маогийнхны явуулсан “их үсрэлтийн” бодлогын учруулсан хор уршгийг зарим талаар цагаатгаж, түүнийг түр зуурын бэрхшээл байсан мэтээр дүрслэн харуулах оролдлого хийжээ.

1947 оноос хойш “соёлын хувьсгалын” өмнөх он-1965 он хүртэлх ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжлийн ололт амжилт алдаа дутагдлыг авч үзэн, зарим сургамжийг нэгтгэн дүгнэх оролдлого хийсэн номын тавдугаар бүлэг анхаарал татаж байна. Үүнд юуны өмнө Өвөр Монголын эдийн засгийн хөгжлийн чиглэлийн тодорхойлох, газар тариалан ба мал аж ахуйн алийг голчлон хөгжүүлэх вэ гэсэн асуудал чухал ач холбогдолтой гэж зохиогчид үзжээ. “Их үсрэлт” зэрэг зарим үеийг эс тооцвол дээрхи хугацаанд мал аж ахуйг голчлон хөгжүүлэх чиг шугам баримталж, Өвөр Монголын мал сүрэг өсөж, зарим амжилтад хүржээ.

Харин дээрхи хугацаанд Өвөр Монголын газар тариалангийн үйлдвэрлэл тогтвортой биш хөгжиж иржээ. Нэг хүнд ноогдох үр тарианы дундаж хэмжээг авч үзвэл, 1949-1952 оны үед 725 цзинь , анхдугаар таван жилд 878 цзинь бож өссөн боловч хоёрдугаар таван жилд 698 цзинь, зохицуулалтын үед 611 цзинь болж буурчээ. (486-р тал)

1947-1965 онд ӨМӨЗО-ы аж үйлдвэрийн бүтээгдэхүүн тооны хувьд багагүй өссөн боловч, ялангуяа хоёрдугаар таван жилд хүнд ба хөнгөн үйлдвэрийн бүтцийн тэнцвэр алдагдаж, үлэмжхэн хохирол үзжээ. Өвөр Монголд томоохон хэмжээний аж үйлдвэрийн газар байгуулахдаа юуны өмнө Хятад улсын эрх ашгийг урьдал болгож, орон нутгийн үндсэн хүн амын эрх ашгийг хохирооход хүргэж байсан нь зохиогчдын бичсэнээс тодорхой байна. Тухайлбал 1952 онд Бугат хотод 139 мянган хүн оршин сууж байсан бол Бугатын төмөрлөгийн үйлдвэрийн барилгыг дагалдан 1965 тус хотын хүн ам 720 мянгад хүрчээ (491-р тал). Ийнхүү хоол хүнс, орон сууц зэрэг зохих урьдчилсан нөхцлийг хангахгүйгээр хотын хүн ам түргэн өсөж байсан нь нутгийн ард түмний амьдралд дарамт болж байжээ.

1959 оноос хойш Өвөр Монголын үндсэн хүн ам ба хятад биш бусад ард түмнийг өргөн хэрэгцээг бараагаар хангах талаар тун бага анхаарах болсныг зохиогчид хүлээн зөвшөөрчээ. 1961 оныг 1958 онтой харьцуулбал мал аж ахуй эрхэлдэг районы нэг хүнд ноогдох барааны дундаж хэмжээ даруй 31,5 хувь буурчээ. Үүнд монгол гутал, хөвөн бүс бараа, торго, элсэн чихэр, шүдэнз зэрэг бараа янз бүрийн хэмжээгээр ховорджээ. (494-р тал)

Өгүүлэн бүхий хугацаанд ӨМӨЗО-ы хүн ам асар түргэн өсөж ирсэн нь тус районы эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөөлснийг зохиогчид цохон тэмдэглэжээ. 1965 онд 1947 онтой харьцуулбал тус районы хүн ам 5 сая 617 мянгаас 12 сая 964 мянга хүртэл өссөн байна. (521-р тал) Ялангуяа хотын хүн ам хэт түргэн нэмэгдэж 1947 оноос 1962 оны эцэс гэхэд хөдөө тосгоны хүн ам 81% өссөн бөгөөд хотын хүн ам даруй 3 илүү дахин өсчээ.

1958-1960 оны хооронд жилд дунджаар 550 мянган хятад хүмүүсийн Өвөр Монголд шилжүүлэн суурьшуулж байсан бөгөөд зөвхөн 1960 онд 945 мянган хятад хүмүүсийг ирүүлж суулгажээ. (526-р тал) Үүнээс үндэслэн цаашид ӨМӨЗО-ы хүн амын өсөлтийг улс ердийн аж ахуйн төлөвлөгөөнд тусган зохицуулахын чухлыг зохиогчид санал болгожээ.

Эцэст нь тэмдэглэхэд энэхүү номонд орсон олон тооны баримт нь БНХАУ-ын ӨМӨЗО-ы аж ахуйг хөгжүүлэхэд түүний үндсэн хүн амын эрх ашгийн дагуу эдийн засгийн бодлого явуулахын чухал болохыг нотолж байна.

**Ц.Батбаяр**